ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

2026.09

СТАТИСТИК ТОЙМ

Үзүүлэлтүүд	Нэгж	Тайлант хугацаа	Өмнөх үе	Өмнөх оны мөн үе	Жилийн өсөлт
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026Q2	**2026Q1**	**2025Q2**	
Бодит ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр)	тэрбум төгрөг	**16,428**	6,736	15,257	7.7%
Нэрлэсэн ДНБ	тэрбум төгрөг	**51,338**	23,024	40,061	28.1%
Ажилгүйдлийн түвшин	%	**5.5%**	5.7%	4.5%	1.0
Өрхийн сарын дундаж орлого, нэрлэсэн	мянган төгрөг	**3,497**	3,490	3,305	5.8%
Өрхийн сарын дундаж зарлага, нэрлэсэн	мянган төгрөг	**3,273**	3,391	3,094	5.8%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M8	**2026M7**	**2025M8**	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	**14,400**	12,206	9,160	57.2%
Зэс	сая ам.доллар	**6,291**	5,461	3,445	82.6%
Нүүрс	сая ам.доллар	**5,325**	4,637	3,372	57.9%
Нийт импорт	сая ам.доллар	**8,865**	7,158	7,479	18.5%
Хэрэглээ	сая ам.доллар	**2,363**	2,043	2,431	-2.8%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар	**3,356**	2,861	3,081	8.9%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	**793**	683	592	33.9%
Шатахуун	сая ам.доллар	**1,849**	1,557	1,365	35.5%
Тэнцэл	сая ам.доллар	**5,240**	5,048	1,681	2.6x
Түүхий эдийн үнэ (Primary Commodity Prices, IMF, Монголбанк)					
Зэс	$/тонн	**14,492**	14,215	9,369	57.4%
Нүүрс (хилийн)	$/тонн	**77.6**	70.7	56.8	36.6%
Алт	$/трой унц	**4,364**	4644	2,597	68.0%
Газрын тос	$/баррел	**102**	92	74	37.8%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	**-2,206**	- 2161	- 1,248	73.2%
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төгрөг	**20,075**	15,588	18,072	11.1%
Төсвийн нийт зарлага	тэрбум төгрөг	**22,236**	19,507	19,320	15.1%
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	**54,401**	53,124	43,618	24.7%
Инфляц	%	**12.5%**	13.0%	8.8%	%
Бодлогын хүү	%	**12.5%**	12.5%	12.0%	0.5%
Жигнэсэн дундаж хүү					
Төгрөгийн хадгаламжийн ЖДХ (шинээр татсан)	%	**11.74%**	11.44%	11.72%	0.00%
Валютын хадгаламжийн ЖДХ (шинээр татсан)	%	**4.20%**	4.13%	3.45%	21.74%
Төгрөгийн зээлийн ЖДХ (шинээр олгосон)	%	**17.56%**	17.41%	17.03%	0.86%
Валютын зээлийн ЖДХ (шинээр олгосон)	%	**10.39%**	11.05%	11.03%	-6%
Гадаад секторын үзүүлэлтүүд					
ГВАН	сая ам.доллар	**8,372**	7,962	5,683	47.3%
Төлбөрийн тэнцэл	сая ам.доллар	**260**	567	-50	620%
Нэрлэсэн ханш (хугацааны эцэст)	Төгрөг/$	**3595**	3593	3,593	0.05%
Урсгал данс	сая ам.доллар	**70**	207	-143	148%
Санхүүгийн данс	сая ам.доллар	**221**	209	147	50%

ОЛОН УЛСЫН ТОЙМ

АНУ-ын эдийн засгийн өсөлт,
жилийн өсөлтийн хувь



АНУ-ын инфляц
жилийн өсөлийн хувь



БНХАУ-ын эдийн засгийн өсөлт,
жилийн өсөлтийн хувь



БНХАУ-ын үнийн индекс,
жилийн өсөлтийн хувь



АНУ-ын Холбооны нөөцийн банк (ХНБ) 3 жилийн дараа анх удаа бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн нь онцлох үйл явдал байлаа. Бодлогын хүүг 25 суурь нэгжээр нэмэгдүүлж, 3.75%-4.00%-д хүргэсэн ба энэ нь инфляцын түвшин Төв банкны хүлээлтээс өндөр түвшинд удаан хадгалагдаж байгаатай холбоотой байна. **ХНБ-ны энэхүү шийдвэр нь зөвхөн АНУ төдийгүй дэлхийн эдийн засагт ч нөлөөлөхөөр байна.** Бодлогын хүү өссөнөөр ам.долларын ханш чангарч, дэлхийн санхүүгийн зах зээл дэх санхүүжилтийн өртөг нэмэгдэх хандлагатай болдог. Үүний үр дүнд хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах, үндэсний валютын ханш сулрах, хөрөнгө оруулалтын идэвх буурах эрсдэл нэмэгддэг. Монгол Улс зэрэг хөгжиж буй эдийн засгуудын хувьд гадаад эх үүсвэрийн өртөг өсөхөөс гадна валютын ханшид ирэх дарамт улам нэмэгдэх сорилт үүсэж байна.

БНХАУ-ын эдийн засаг 2026 оны 2-р улиралд эдийн засаг 4.3%-иар өсөж, 2022 оны сүүлээс хойших хамгийн бага түвшинд хүрсэн байна. Ийнхүү эдийн засаг саарахад дотоодын эрэлт сул, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт буурсан, мөн үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэл үргэлжилсэн нь голлон нөлөөлжээ. Хэдийгээр хиймэл оюун ухаан болон орчин үеийн технологийн бүтээгдэхүүний экспорт эрчимтэй өссөн ч эдгээр нь эдийн засгийн бусад салбарын сулралыг бүрэн нөхөж чадаагүй байна.

Харин хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар өсөж өмнө жилүүдэд дефляцитай байсан үнийн индекс энэ жил эерэг болж өөрчлөгдсөн байна. Инфляцын өсөлтөд тээвэр, хувцас, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний үнэ нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бол дотоод эрэлт суларсантай холбоотойгоор орон сууц болон хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт сул хэвээр байна. Харин үйлдвэрлэгчдийн үнийн индекс 3.8%-иар өссөн нь эрчим хүч болон үйлдвэрлэлийн түүхий эдийн үнэ нэмэгдсэнтэй холбоотой байв.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ









2026 оны 8-9 дүгээр сарын түүхий эдийн үнийн савлагаанд АНУ-Ираны дайны нөхцөл байдал голлон нөлөөлсөн хэвээр байна. Тодруулбал, мөргөлдөөний улмаас Ормузын хоолойгоор дамжих газрын тосны тээвэр доголдож, мөн Йемений Хуситууд Саудын Арабын газрын тосны дэд бүтэц, экспортын шугамуудад удаа дараа халдсанаар Саудын Арабын олборлолт 8 дугаар сард өмнөх сараас 23%-иар буурсан байна.

Үүний зэрэгцээ Украин Оросын газрын тосны байгууламжуудад дроны цохилтоо эрчимжүүлснээр дэлхийн нийлүүлэлт хумигдаж, Брент газрын тосны үнэ 8-9 сард 22%-иар өсөв. Газрын тосны нийлүүлэлт доголдож, үнэ өссөнөөр нүүрсийг орлох эрчим хүчний эх үүсвэр болгон ашиглах эрэлт нэмэгдэж, нүүрсний үнэ мөн 13%-иар өссөн байна. Харин эрчим хүчний зах зээлийн хомсдол, металлын зах зээл дэх нийлүүлэлтийн дарамтын нөлөөгөөр зэсийн үнэ 4.5%-иар өссөн ч өндөр хүүгийн орчин өсөлтийг хязгаарлалаа.

Нөгөө талаас геополитикийн эрсдэл, эрчим хүч болон хүнсний үнийн өсөлтөөс үүдэлтэй инфляцын хүлээлт нь алтны эрэлтийг дэмжсэн. Гэвч АНУ-ын Холбооны Нөөцийн Банк (Fed), Европын Төв Банк (ECB) болон Канадын Төв Банк инфляцын эрсдэлтэй холбоотойгоор бодлогын хүүг өндөр түвшинд хадгалах, шаардлагатай тохиолдолд нэмж өсгөх байр суурια илэрхийлсэн нь алтны үнийн өсөлтийг хязгаарлаж, алтны үнэ 8-9 сард 4,300-4,400 ам.доллар/унцын орчимд хэлбэлзэхэд хүргэсэн.

Дүгнэвэл, АНУ-Ираны дайн болон Ойрхи Дорнод дахь нийлүүлэлтийн доголдол нь эрчим хүчний зах зээлд хамгийн хүчтэй нөлөөлж, газрын тос (+22%) болон нүүрсний (+13%) үнийг огцом өсгөсөн бол зэс (+4.5%) нийлүүлэлтийн хүчин зүйлсээр дэмжигдсэн байна. Харин алтны аюулгүй хөрөнгийн эрэлт хэвээр хадгаладаж буй ч өндөр бодлогын хүүний хүлээлтийн улмаас ханш харьцангуй тогтвортой түвшинд байна.

ДОТООД ЭДИЙН ЗАСАГ:
МАКРО ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эдийн засгийн өсөлт, нэрлэсэн ДНБ



Инфляц ба Бодлогын хүү



Банкны зээлийн өсөлтийн хувь



Сарын дундаж нэрлэсэн цалин



2026 оны 7-р сарын байдлаар эдийн засгийн өсөлт 7.6%-тай гарч өмнөх саруудаас бага зэрэг саарлаа. Өсөлтийн тал хэсгийг уул уурхайн салбарын өсөлт бий болгосон буюу 3.7 нэгж хувийг эзэлсэн бол хөдөө аж ахуйн салбар 1.5 нэгж хувиар удаалжээ. Уул уурхайг дагаж тээврийн салбар өндөр гүйцэтгэлтэй байсан буюу 0.8 нэгж хувийг бүрдүүлсэн бол худалдааны салбарын хувьд оны туршид идэвхжил сул байж 7-р сарын байдлаар өнгөрсөн оноос 0.8 хувь буурч өсөлтөд -0.01 нэгж хувийг оролцоог бий болгожээ.

2026 оны 8 дугаар сарын байдлаар инфляц 12.5%-д хүрч, өмнөх сарын 13.0%-ийн түвшнээс бага зэрэг саарлаа. Инфляцын өсөлтийн гол үүсвэр нь хүнсний бүлэг байсан бөгөөд нийт инфляцын 5.8 нэгж хувийг бүрдүүлжээ. Тэр дундаа мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 48.4%-иар өссөн нь үнийн дарамтыг өндөр түвшинд хадгалсан хэвээр байна. Цаашид махны үнэ улирлын хандлагаараа буурах хүлээлттэй байгаа ч шатахууны нийлүүлэлтийн хомсдол, төсвийн тэлэлт зэрэг нь инфляцын эрсдэлийн гол хүчин зүйлс хэвээр байна.

2026 оны 8 дугаар сарын байдлаар нийт зээлийн жилийн өсөлт 14.3%-д хүрч, өмнөх сарын 13.0%-ийн түвшнээс өссөн байна. Нийт зээлийн өсөлтийг бизнесийн зээл голлон дэмжсэн бөгөөд жилийн өсөлт нь 17.8%-д хүрчээ. Харин хэрэглээний зээлийн өсөлт 4.7% хүртэл саарч, оны эхэн үеийн түвшнээс мэдэгдэхүйц буурсан байна. Нөгөө талаас нийт зээлийн 5.3%-ийг чанаргүй зээл бүрдүүлж байгаа ч анхаарал хандуулах зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35.5%-аар буурсан нь зээлийн чанарт эерэг дохио болж байна.

Улсын дундаж нэрлэсэн цалин 3.0 сая төгрөг байгаа ба уул уурхайн салбарын ажилчдын цалин хамгийн өндөр буюу 5.2 сая төгрөг байна. Нийт цалингийн хэмжээг ажиллагсдын тоонд харьцуулсан энэхүү үзүүлэлтээр 8-р сард хамгийн бага цалинтай салбар нь зочид буудал нийтийн хоолны салбар байгаа бөгөөд дундаж цалин 2.1 сая төгрөг байна. Оны эхнээс хамгийн ихээр өссөн салбар нь зочид буудал, нийтийн хоол салбар (11.1%) байгаа бол хамгийн их буурсан салбар нь цахилгаан, хий салбар (38.2%) байна.

ДОТООД ЭДИЙН ЗАСАГ:
ГАДААД ХУДАЛДАА









2026 оны эхний найман сарын гүйцэтгэлээр нийт экспорт 14,400 сая ам.доллар, нийт импорт 8,373 сая ам.долларт хүрч тус бүр харгалзан 57.2 ба 11.9 хувиар өсжээ. Улмаар худалдааны ашиг 6,027 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 дахин өслөө.

Нийт экспортын 44 хувийг зэсийн баяжмалын экспорт, 37 хувийг чулуун нүүрсний экспортын орлого тайлбарлаж байна. Тухайлбал өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын орлого 118 хувиар, нүүрсний орлого 83 хувиар, мөн алтны экспортын орлого 71 хувиар өсөөд байна. Харин нефтийн бүтээгдэхүүний импорт өмнөх оны мөн үеэс 35.5 хувиар өссөн нь нийт импортын өсөлтийг голлон тайлбарлаж байна.

Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ эхний найман сарын хуримтлагдсан дүнгээр 1,767.7 мянган тонн хүрсэн ба сарын дүнгээр 238.8 мянган тоннд хүрчээ. Мөн сарын дундаж хилийн үнэ тонн тутамд 3,472.8 ам.доллар болж өмнөх сараас бага зэрэг буурсан ч өмнөх оны мөн үеэс 30 хувийн өсөлттэй байна. Цаашид цахилгаан автомашин, эрчим хүчний шилжилт, хиймэл оюун ухааны дэд бүтцээс шалтгаалан эрэлт нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ 8-р сард 8,865 сая тоннд хүрч, хилийн үнэ тонн тутамд 77.6 $/тонн-д хүрээнд байна. Экспортын өсөлтөд БНХАУ-ын коксжих нүүрсний импортын эрэлт өндөр хэвээр байгаа нь голлон нөлөөлжээ. Тухайлбал, БНХАУ 2026 оны эхний долоон сард нийт 80.5 сая тонн коксжих нүүрс импортолсон нь өмнөх оны мөн үеэс 28.9 хувиар өссөн үзүүлэлт болсон бол үүнээс Монгол Улс 46.8 сая тонн нүүрс нийлүүлж, энэ нь өмнөх оны мөн үеэс 57.4 хувиар өссөн үзүүлэлт болж байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, нүүрсний экспортын орлогын өсөлт болон гадаад валютын орох урсгал нэмэгдсэнээр Монгол Улсын гадаад валютын улсын албан нөөц 2026 оны 8 дугаар сарын эцэст 8.3 тэрбум ам.долларт хүрчээ. Харин төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3,595 төгрөгт хүрч, оны эхнээс 0.9 хувиар сулраад байна.

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

7575-1111 /1277/
eru@golomtbank.com
www.dua.golomtbank.com

Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны хэлтэс нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.